



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2022 оны ээлжит 03 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 03 дугаар хуралдааныг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар ХХЗХ-ны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн тухай; ХХЗХ-ны үндсэн хөрөнгө актлах саналын тухай; Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар танилцуулга (-Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшил; -Гадаад сувгийн мэдээлэл, бүртгэлийн тухай); Тусгай зөвшөөрлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Хорооны 2021 оны 13 дугаар хуралдааны тэмдэглэл); Тусгай тусгай зөвшөөрлийн талаар үнэлгээ, дүгнэлтийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох тухай, тусгай зөвшөөрөл сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах тухай) зэрэг 8 асуудлыг тус тус хэлэлцэж, зохицуулах хорооны 4 тогтоолыг батлан шийдвэрлэв. Түүнчлэн тус хуралдааны 2 тэмдэглэлээр бүтцийн нэгжийн удирдлагад хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэлийг өгсөн болно.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар ЗУХАГ, ажлын хэсгээс нэгтгэн боловсруулсан “Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасаж, актлах саналын тухай” танилцуулга, тогтоолын төсөл, 3 хавсралт бүхий актлах эд хөрөнгийн жагсаалтын төслийг тус тус авч хэлэлцээд, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, байгууллагын 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийг тоолсон ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 11 тоот “Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасаж, актлах саналын тухай” тогтоолыг батлан шийдвэрлэв. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар ашиглалтын хугацаа дууссан, хэрэгцээ хангахгүй болсон 24 нэр төрлийн 50,179,607 (тавин сая нэг зуун далан есөн мянга зургаан зуун долоон) төгрөгийн анхны өртөгтэй машин тоног төхөөрөмжүүдийг актлах, устгах саналыг; 2 дугаар хавсралтаар заасан ашиглалтын хугацаа дууссан, хэрэгцээ хангахгүй болсон 9 нэр төрлийн 36,724,070 (гучин зургаан сая долоон зуун хорин дөрвөн мянга далан) төгрөгийн анхны өртөгтэй программ хангамжийг үндсэн хөрөнгөөс хасаж актлах, устгах саналыг тус тус Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх; 3 дугаар хавсралтаар ашиглалтын хугацаа дууссан, хэрэгцээ хангахгүй болсон 49 нэр төрлийн 7,932,241 (долоон сая есөн зуун гучин хоёр мянга хоёр зуун дөчин нэгэн) төгрөгийн анхны өртөгтэй бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг хасаж актлах, устгахаар шийдвэрлэв.

Тус хуралдаанаар холбогдох бүтцийн газар, нэгжээс боловсруулсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар танилцуулга (Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшил; Гадаад сувгийн мэдээлэл, бүртгэлийн тухай) танилцуулгыг тус тус сонсов.

Энэхүү хорооны хуралдаанаар ЗУХАГ-аас нэгтгэн боловсруулсан “Тусгай зөвшөөрлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Хорооны 2021 оны 13 дугаар хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт)” судалгаа танилцуулга, үндэслэл тайлбар, хорооны хуралдааны тэмдэглэлийн төсөл, хавсралт жагсаалтын төслийг тус тус авч хэлэлцээд, тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эхлээгүй байгаа хавсралтад заасан нэр бүхий 6 үйлчилгээ эрхлэгч болон 2021 оны хорооны хуралдааны 13 дугаар тэмдэглэлийн хавсралтад заасан радио, телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч 19 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаа эхлэх хугацааг Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэлээр 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үйл ажиллагаа эхлээгүй боловч олгогдсон тусгай зөвшөөрөл, радио давтамж, зохицуулалтын үйлчилгээний өр төлбөрийг бүрэн барагдуулсан байх; тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан статистик мэдээлэл, тайланг ирүүлсэн байх, ирүүлээгүй тохиолдолд албан тоотой тайлбараа ирүүлсэн байх; тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаагаа нэг жилийн дотор эхлээгүй талаарх хүндэтгэн үзэх шалтгаан, нөхцөлөө нотолсон дэлгэрэнгүй тайлбар, хүсэлт, нотлох баримтыг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлсэн байх нөхцөлтэйгөөр хойшлуулах нь зүйтэй гэж хорооны 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 03 тоот “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тэмдэглэлийг гаргахаар тогтов. Энэхүү тэмдэглэлээр өгсөн удирдамж чиглэлийг баримтлан ажиллах, хэрэгжилтийг хангуулах, хавсралтад заасан нэр бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн тайлбар, мэдээлэл, нотлох баримтыг нэгтгэн боловсруулж, 2022 онд багтаан хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг холбогдох газар, хэлтэст тус тус үүрэг болгов.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 03 дугаар хуралдаанд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Төсвийн тухай хуулийн 8.9.8 заалт болон Хорооны даргаас өгсөн удирдамж, чиглэлийн хүрээнд ЗУХАГ болон ДХАА-наас нэгтгэн боловсруулсан “ХХЗХ-ны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн тухай” танилцуулга, төлөвлөгөөний гүйцэтгэл болон санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмж, хуралдааны тэмдэглэлийн төслийн авч хэлэлцээд, Хорооны хуралдааны 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 04 дүгээр “Хорооны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай” хуралдааны тэмдэглэл гаргахаар шийдвэрлэсэн. Уг тэмдэглэлд, Зохицуулах хорооны 2021 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан материаллаг алдаагүй, НББ-ийн тухай хууль, СТОУС-д нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан тул “**Зөрчилгүй**” санал дүгнэлт гаргасан Аудитын гэрчилгээнд илэрхийлсэн байдал, аудиторын зүгээс өгсөн зөвлөмжүүдийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан хэрэгжүүлж ажиллахыг Хорооны дэд дарга /Д.Сэрээдорж/, Санхүүгийн хэлтэс /Н.Халиунаа/-д тус тус үүрэг болгов.

Хорооны 2022 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөл сэргээх тухай”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 3 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 3 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны

зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 08 тоот тогтоолын хавсралтаар 23 хуулийн этгээдэд 26 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 09 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дах заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалт болон 5.3 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 10 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулсан болно.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2022-04-06